



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/419

Булган сум

Аймгийн Прокурорын газарт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Булган аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ын 5.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймагт зохион байгуулагдаж буй Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган аймгийн Прокурорын байгууллагуудын дундах “Урлагийн наадам”-д 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

